



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

**Дүүргийн Авлигын эсрэг үйл ажиллагааны
2024 оны төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд зохион байгуулах Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулж, холбогдох зардлыг тухай бүр санхүүжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 103 дугаар сарын 10-ны өдрийн... дугаар
захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хугацаа (улирал)	Хариуцах нэгж, байгууллага
1	2 Авлигын эсрэг хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	3 1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх 1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах 1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын	4 Түгээсэн тоо, давтамж, авсан хандалт / тоо	5 420ш гарын авлага тараасан	6 300ш гарын авлага тараах	7 I-IV улирал	8 Засаг даргын Тамгын газар, Аж ахуйн нэгж байгууллагууд
1.			Өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа / тоо	2 өдөрлөг, 1 аян	2-оос доошгүй	I, III, IV улирал	Засаг даргын Тамгын газар
			Сурталчилгааны материал боловсруулах /тоо	2 гарын авлага	2-оос доошгүй	I-IV улирал	Засаг даргын Тамгын газар

		мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах							
		1.4.Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	Видео контент /тоо	-	2-оос доошгүй	I-IV улирал	Засаг даргын Тамгын газар		
		2.1. "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх	Олон нийтийн хяналт/тоо	-	1-ээс доошгүй	I-IV улирал	Засаг даргын Тамгын газар		
		2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	Төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгаа/тоо	-	1-ээс доошгүй	I-IV улирал	Засаг даргын Тамгын газар		
2.	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.3.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	2024 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт / мян, төг	1204 иргэн санал/ асуулгын явц 46.2%	12-өөс доошгүй нээлттэй мэдээлэх	I-IV улирал	Засаг даргын Тамгын газар		
		2.4.Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших	Гомдол, мэдээллийн судалгааг /тоо	342 өргөдөл/ 92%	Судалгааг тогтмол гаргаж, тайлагнах	I-IV улирал	Засаг даргын Тамгын газар		
3.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга	3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг	Үйлчилгээний чанар, хүртээмж /тоо	Нэвтрүүлсэн үйлчилгээ 1	2-оос доошгүй судалгаа, санал асуулга авах	I-IV улирал	Засаг даргын Тамгын газар		

хэмжээ авах	<p>дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах</p> <p>3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх</p> <p>3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол /тоо	-	Тухай бүр	I-IV улирал	Засаг даргын Тамгын газар
4. "Шударга байдлын үнэлгээ"- ний үзүүлэлтийг сайжруулах	<p>4.1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, үр дүнг тооцож, тайлагнах</p> <p>4.2. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг шударгаар үнэлэх, үнэлгээг албан хаагч бүрд танилцуулах</p> <p>4.3. Хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах, чадахуйн /мерит/ зарчмыг үндэслэн шатлан дэвшүүлэх</p> <p>4.4. Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг хагас, бүтэн жилд нийт албан хаагчдад танилцуулах</p>	<p>Шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ /тоо</p> <p>Зөвлөмж, саналыг хүлээн авах, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах /тоо</p> <p>Ажлын чанар үр дүн /тоо</p> <p>Нээлттэй ил тод мэдээлэх /тоо</p> <p>Арга хэмжээ зохион байгуулах /тоо</p>	<p>Шүүр- 4 Шүгэл -420ш Шил -5</p> <p>2 удаа /49 албан хаагч</p> <p>11 сул орон тоо, 9 албан хаагч</p> <p>3 удаа хэлэлцүүлж, 2 санал гарсан</p>	<p>400-аас доошгүй</p> <p>2 удаа/ 40-еос доошгүй</p> <p>3 түүнээс дээш сул орон тоо</p> <p>3-ас доошгүй хэлэлцүүлэх</p>	<p>I-IV улирал</p> <p>II-IV улирал</p> <p>I-IV улирал</p> <p>II-IV улирал</p>	<p>Засаг даргын Тамгын газар</p> <p>Засаг даргын Тамгын газар</p> <p>Засаг даргын Тамгын газар</p> <p>Засаг даргын Тамгын газар</p>